

БАТЛАВ.

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР,  
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ДАРГА Э.ЭНХТУУЛ

2024 ОНЫ 02 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР

ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ  
БАЙГУУЛЛАГЫГ ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН  
БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын нэр:

*Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн  
үйлчилгээг үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах*

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

*СХДХХҮХ/20240203002*

Улаанбаатар хот  
2024 он

## САНАМЖ

Тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер нь захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний гол нөхцөл болох тул тендер шалгаруулалт зохион байгуулах, түүнд оролцохын өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, түүнийг даган батлагдсан журам, заавар, дүрэм, гэрээний нөхцөл, тендер шалгаруулалтын жишиг баримт бичигтэй сайтар танилцахыг зөвлөж байна.

Захиалагч нь тендер шалгаруулалт зохион байгуулахад худалдан авах ажиллагааны үндсэн зарчмууд болох өрсөлдөх боломжтой, ил тод, хариуцлагатай, үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг баримтална.

Энэхүү харьцуулалтын аргын тендер шалгаруулалтын баримт бичиг нь тендер шалгаруулалтын зааварчилгаа, өгөгдлийн хүснэгт, техникийн тодорхойлолтын шаардлага, тендерийн жишиг маягт, гэрээний нөхцөл гэсэн бүлэгтэй.

Тендер шалгаруулалтын зааварчилгаа бүлгийн зүйл, заалтыг нэмж, эсхүл өөрчилж үл болно. Захиалагч өгөгдлийн хүснэгтийг зааварчилгаатай уялдуулан боловсруулах ба шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

Техникийн тодорхойлолт бүлэгт захиалагчийн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгасан байна.

Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд үндэслэн жишиг маягтуудын хаалт дотор налуугаар бичсэн тохирох мэдээллийг зааварт нийцүүлэн бүрэн, үнэн зөв бөглөж ирүүлнэ. Гэрээний нөхцөл бүлэг нь захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулагдах гэрээний зүйл, заалтуудыг агуулсан байна.

Харьцуулалтын аргын тендер шалгаруулалтын анхаарах асуудлууд:

- ❖ Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээ /Ажил цахим каталогт бүртгэгдсэн байна./
- ❖ Тендер шалгаруулалтын зарлал нийтэлж, бүртгэлтэй аж ахуй эрхлэгчид урилга хүргүүлж, үнийн санал дуудна. Тендер шалгаруулалтын баримт бичгийг цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлнэ.
- ❖ Үнийн саналыг дуудах хугацаа нь урилга хүргүүлсэн, зарлал нийтэлсэн өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй өдрийн дараа байхаар тогтоосон байна.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээдэд цахим системээс ялгах дугаар олгоно.
- ❖ Заасан хугацаанд сонирхогч этгээд тендерийг цахим системд ирүүлнэ.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагааг 2 хүртэл цагийн хугацаагаар зохион байгуулна. Уг хугацааны дотор саналыг бууруулан хэдэн ч удаа ирүүлж болно.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад өсөх дарааллаар **эхэнд эрэмбэлэгдсэн** үнийн санал бүхий оролцогчийг тодорхойлно.
- ❖ Эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн **тендерийг хянан үзэж, шаардлага хангасан бол гэрээ байгуулах эрх олгоно.**

Эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол **удаах эрэмбэлэгдсэн** тендерийг хянан үзнэ.

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА .....	3
II БҮЛЭГ.ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ .....	9
III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	
III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	2
V БҮЛЭГ.ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ .....	1
VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ .....	

# I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

## А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ  
1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон үйлчилгээ (цаашид “үйлчилгээ” гэх) авах тендер шалгаруулалтын баримт бичгийг гаргаж байна. Тендер шалгаруулалтын нэр, дугаар, багцын мэдээлэл өгөгдлийн хүснэгтэд бичигдэнэ.
2. Санхүүжилтийн эх үүсвэр  
2.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр, төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж  
3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.  
3.2. Худалдан авах ажиллагаанд захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.  
3.3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй.
4. Оролцогчид тавигдах ерөнхий шаардлага  
4.1. Оролцогч хуулийн 7.1.1-7.1.9-д заасан нөхцөлийг хангасан байна.  
4.2. Түншлэлээр оролцох тохиолдолд түншлэлийн гишүүн бүр ерөнхий шаардлага хангасан байна.  
4.3. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.  
4.4. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.  
4.5. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
5. Туслан гүйцэтгэгч  
5.1. Хуулийн 6.4-т зааснаар тендерийн үнийн 20 хүртэл хувьтай тэнцэх гүйцэтгэлийг нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдээр туслан гүйцэтгүүлэх тохиолдолд туслан гүйцэтгүүлэх мэдээллийг гэрээнд заасан байна.  
5.2. Туслан гүйцэтгүүлэх хувь хэмжээ тендерийн үнийн 20 хувиас хэтэрсэн, эсхүл туслан гүйцэтгүүлэх тоо хэмжээг заагаагүй бол туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.  
5.3. Туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
6. Худалдан авах ажиллагааны цахим систем  
6.1. Харьцуулалтын аргаар үйлчилгээ авах тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

## **Б.АГУУЛГА**

### **7. Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл**

7.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг дараах бүлэг болон түүний нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ.

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн жишиг маягт;

V Бүлэг. Гэрээний нөхцөл

7.2. Тендер шалгаруулалтын зарлал, цахим системээр хүргүүлсэн урилга нь тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл болохгүй.

7.3. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

### **8. Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах**

8.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

8.2. Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

8.3. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

8.4. Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн тооцно.

8.5. Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 9-д заасныг мөрдөнө.

### **9. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах**

9.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

9.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

9.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

### **10. Тендер ирүүлэхийн уулзалт өмнөх**

10.1. Захиалагч сонирхогч этгээдийн тендер бэлтгэхтэй холбоотой асуултад хариулт өгөх уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. Уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

## **В.Тендер бэлтгэх**

### **11. Тендер шалгаруулалтын хэл**

11.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

11.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл,

тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

11.3. Хэрэв ТШЗ-ны 11.2-т заасан тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

11.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

## **12. Тендерийн бүрдэл**

12.1. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

12.1.1. ТШЗ-ны 13-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

12.1.2. Тендерийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

12.1.3. өгөгдлийн хүснэгтэд заасан бол ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

12.1.4. ТШЗ-ны 15-д зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

12.1.5. ТШЗ-ны 16, 17, 18-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

12.1.6. ТШЗ-ны 19-д заасны дагуу ажлыг техникийн тодорхойлолтын шаардлагад гүйцэтгэхийг нотлох баримт бичиг;

12.1.7. ТШЗ-ны 22.4-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

12.2. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

## **13. Тендерийн жишиг маягт**

## **14. Хувилбарт санал**

13.1. IV бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

14.1. өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт илгээж болно.

## **15. Ерөнхий шаардлага**

15.1. IV бүлгийн Маягт 1-ийн дагуу бэлтгэсэн хуулийн 7.2-т заасан мэдэгдэл ирүүлнэ.

15.2. Хуулийн 7.1-д заасан ерөнхий нөхцөлийг магадлахтай холбоотой ирүүлэх баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заана.

15.3. Түншлэлийн гишүүн тус бүр ерөнхий шаардлага хангасан байх ба нотлох баримт бичиг ирүүлнэ.

## **16. Чадавхын болон туршлагын шаардлага**

16.1. ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

16.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

16.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн тус бүр болон хамтдаа чадавхын болон туршлагын шаардлагыг өгөгдлийн хүснэгтэд хүснэгтэд заасан хувь, хэмжээгээр хангасан байна.

## **17. Санхүүгийн чадавхын шаардлага**

17.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

- 17.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 17.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн тус бүр болон хамтдаа хангавал зохих шаардлагыг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 18. Техникийн болон туршлагын шаардлага**
- 18.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.
- 18.2. Техникийн болон туршлагын чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 17.2-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 18.3. Үйлчилгээ үзүүлэхэд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл шаардлагатай бол өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19. Үйлчилгээг техникийн тодорхойлолтод заасны дагуу гүйцэтгэхийг нотлох баримт**
- 19.1. Оролцогч үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад санал болгосон эцсийн үнээр захиалагчийн баталсан ажлын даалгаврын дагуу үйлчилгээ үзүүлэх тухай мэдэгдлийг IV бүлгийн маягт 1-ийн дагуу баталгаажуулж ирүүлнэ.
- 20. Тендерийн үнэ**
- 20.1. Үнийн санал ажиллагаа хаагдахад санал болгосон үнэ оролцогчийн тендерийн үнэ байна.
- 20.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй.Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 20.3. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21. Тендерийн валют**
- 21.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлнэ.
- 22. Тендерийн үнэ**
- 22.1. Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад санал болгосон үнэ оролцогчийн тендерийн үнэ байна.
- 22.2. Тендерийн үнэ гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх эсэхийг өгөгдлийн хүснэгтэд заана. Өгөгдлийн хүснэгтэд тогтмол байхаар заасан тохиолдолд тохируулга хийх нөхцөлтэй тендер ирүүлсэн бол шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 22.3. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 22.4. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

- 23. Тендер хүчинтэй хугацаа** байх
- 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.
- 23.2. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.
- 23.3. Оролцогч хугацааг сунгасан бол хуулийн 28.9-д зааснаар бичгээр мэдэгдэнэ.

#### **Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ**

- 24. Тендер баталгаажуулах, илгээх**
- 24.1. Тендерийг хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулан илгээнэ.
- 24.2. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол IV бүлэгт заасан маягыг ТШЗ-ны 24.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
- 24.3. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг IV бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
- 24.4. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 24.3-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

- 25. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 25.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

#### **Д.ҮНИЙН САНАЛ ДУУДАХ АЖИЛЛАГАА**

- 26. Үнийн санал дуудах хугацаа**
- 26.1. Хуулийн 34.6-д зааснаар үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээдийн тоо зарлалд заасан шаардлагатай тоонд хүрсэн тохиолдолд уг ажиллагаа ТШЗ-ны 25.1-д товлосон хугацаанаас нэг цагийн дараа эхэлнэ.
- 26.2. Үнийн санал дуудах ажиллагаа хуулийн 34 дүгээр зүйлд заасан журмын дагуу явагдана.
- 26.3. ТШЗ-ны 26.2-т заасан ажиллагаа урилгад заасан хугацаанд үргэлжилж хаагдана.

- 27. Тендер нээх**
- 27.1. ТШЗ-ны 26.3-т заасан хугацаа хаагдахад цахим систем оролцогч нарын санал болгосон эцсийн үнийг өсөх дарааллаар эрэмбэлэх ба захиалагч эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендерийг нээнэ.

#### **Е.ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**

- 28. Тендерийг шаардлагад нийцэх эсэхийг хянан үзэх**
- 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 12-т тендерийн бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн Сангийн сайдын баталсан зааврын дагуу хянан үзнэ.
- 28.2. Эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол удаах эрэмбэлэгдсэн тендерийг хянан үзнэ.

- 29. Тендерийн талаар тодруулга авах**
- 29.1. Тендерийг хянан үзэх явцад тодруулга авах шаардлагатай гэж үзвэл хуулийн 25 дугаар зүйлийг баримтална.

#### **Ё.МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

- 30. Мэдэгдэл**
- 30.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан



хүргүүлэх

**31. Гүйцэтгэлийн баталгаа**

шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

31.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

31.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

**32. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**

32.1. Захиалагч ТШЗ-ны 7.1-д заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

32.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

32.3. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 32.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчийн тогтоосон хугацааны дотор хүргүүлнэ.

32.4. Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.

**Ж.БУСАД**

**33. Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлах**

33.1. Захиалагч ТШЗ-ны 28.2-т зааснаар хянан үзээд бүх тендерээс татгалзсан бол шаардлага хангасан тендер ирээгүй шалтгааныг судалж, тендер шалгаруулалтыг дахин зарлах эсэх мэдээллийг ТШЗ 30.1-д заасан шийдвэрт заана.

33.2. Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлахад хуулийн 34.11-д заасныг баримтална.

**34. Тендер шалгаруулалтад гомдол гаргах**

34.1. Тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу хянан шийдвэрлэнэ.

**II БҮЛЭГ.ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<p align="center"><b>ТШЗ-ны холбогдох заалт</b></p>	<p align="center"><b>А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b></p>														
<p><b>ТШЗ 1.1</b></p>	<p>Захиалагч: <b>Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс</b></p>														
<p><b>ТШЗ 1.1</b></p>	<p>Зарлалын дугаар: <b>СХДХХҮХ/20240203002</b>  Тендер шалгаруулалтын нэр: <b>Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах</b>  Тендер шалгаруулалтын багцын тоо болон нэр:  <b>Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</b></p> <table border="1" data-bbox="432 678 1458 1346"> <tr> <td data-bbox="432 678 555 792"> <p>Багцын дугаар</p> </td> <td data-bbox="555 678 1458 792"> <p><b>Багцын нэр төрөл, хамаарагдах газарзүйн байршил /тухайн багцад орсон хороодын аль нэг байршилд үйл ажиллагаа явуулдаг ажлын байртай байх/</b></p> </td> </tr> <tr> <td data-bbox="432 792 555 898"> <p>Багц-1</p> </td> <td data-bbox="555 792 1458 898"> <p><b>Сэргээн засах үйлчилгээ:</b>  Өнөр бүс: 12, 13, 14, 15, 16, 17, 18, 29, 30, 31, 43-р хороод,  Толгойт бүс: 1, 2, 3, 4, 20, 22, 26, 33, 34, 35, 36-р хороод</p> </td> </tr> <tr> <td data-bbox="432 898 555 1003"> <p>Багц-2</p> </td> <td data-bbox="555 898 1458 1003"> <p><b>Сэргээн засах үйлчилгээ:</b>  Төвийн бүс: 5, 6, 19, 21, 23, 27, 32, 37, 38, 39-р хороод,  Баянхошуу бүс: 7, 8, 9, 10, 11, 24, 25, 28, 40, 41, 42-р хороод</p> </td> </tr> <tr> <td data-bbox="432 1003 555 1108"> <p>Багц-3</p> </td> <td data-bbox="555 1003 1458 1108"> <p><b>Өдрийн үйлчилгээ:</b>  Өнөр бүс: 12, 13, 14, 15, 16, 17, 18, 29, 30, 31, 43-р хороод,  Толгойт бүс: 1, 2, 3, 4, 20, 22, 26, 33, 34, 35, 36-р хороод</p> </td> </tr> <tr> <td data-bbox="432 1108 555 1214"> <p>Багц-4</p> </td> <td data-bbox="555 1108 1458 1214"> <p><b>Өдрийн үйлчилгээ:</b>  Төвийн бүс: 5, 6, 19, 21, 23, 27, 32, 37, 38, 39-р хороод,  Баянхошуу бүс: 7, 8, 9, 10, 11, 24, 25, 28, 40, 41, 42-р хороод</p> </td> </tr> <tr> <td data-bbox="432 1214 555 1319"> <p>Багц-5</p> </td> <td data-bbox="555 1214 1458 1319"> <p><b>Амьдралын итгэл үнэмшил олгох, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах үйлчилгээ</b></p> </td> </tr> <tr> <td data-bbox="432 1319 555 1346"> <p>Багц-6</p> </td> <td data-bbox="555 1319 1458 1346"> <p><b>Зөвлөгөө өгөх үйлчилгээ</b></p> </td> </tr> </table>	<p>Багцын дугаар</p>	<p><b>Багцын нэр төрөл, хамаарагдах газарзүйн байршил /тухайн багцад орсон хороодын аль нэг байршилд үйл ажиллагаа явуулдаг ажлын байртай байх/</b></p>	<p>Багц-1</p>	<p><b>Сэргээн засах үйлчилгээ:</b>  Өнөр бүс: 12, 13, 14, 15, 16, 17, 18, 29, 30, 31, 43-р хороод,  Толгойт бүс: 1, 2, 3, 4, 20, 22, 26, 33, 34, 35, 36-р хороод</p>	<p>Багц-2</p>	<p><b>Сэргээн засах үйлчилгээ:</b>  Төвийн бүс: 5, 6, 19, 21, 23, 27, 32, 37, 38, 39-р хороод,  Баянхошуу бүс: 7, 8, 9, 10, 11, 24, 25, 28, 40, 41, 42-р хороод</p>	<p>Багц-3</p>	<p><b>Өдрийн үйлчилгээ:</b>  Өнөр бүс: 12, 13, 14, 15, 16, 17, 18, 29, 30, 31, 43-р хороод,  Толгойт бүс: 1, 2, 3, 4, 20, 22, 26, 33, 34, 35, 36-р хороод</p>	<p>Багц-4</p>	<p><b>Өдрийн үйлчилгээ:</b>  Төвийн бүс: 5, 6, 19, 21, 23, 27, 32, 37, 38, 39-р хороод,  Баянхошуу бүс: 7, 8, 9, 10, 11, 24, 25, 28, 40, 41, 42-р хороод</p>	<p>Багц-5</p>	<p><b>Амьдралын итгэл үнэмшил олгох, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах үйлчилгээ</b></p>	<p>Багц-6</p>	<p><b>Зөвлөгөө өгөх үйлчилгээ</b></p>
<p>Багцын дугаар</p>	<p><b>Багцын нэр төрөл, хамаарагдах газарзүйн байршил /тухайн багцад орсон хороодын аль нэг байршилд үйл ажиллагаа явуулдаг ажлын байртай байх/</b></p>														
<p>Багц-1</p>	<p><b>Сэргээн засах үйлчилгээ:</b>  Өнөр бүс: 12, 13, 14, 15, 16, 17, 18, 29, 30, 31, 43-р хороод,  Толгойт бүс: 1, 2, 3, 4, 20, 22, 26, 33, 34, 35, 36-р хороод</p>														
<p>Багц-2</p>	<p><b>Сэргээн засах үйлчилгээ:</b>  Төвийн бүс: 5, 6, 19, 21, 23, 27, 32, 37, 38, 39-р хороод,  Баянхошуу бүс: 7, 8, 9, 10, 11, 24, 25, 28, 40, 41, 42-р хороод</p>														
<p>Багц-3</p>	<p><b>Өдрийн үйлчилгээ:</b>  Өнөр бүс: 12, 13, 14, 15, 16, 17, 18, 29, 30, 31, 43-р хороод,  Толгойт бүс: 1, 2, 3, 4, 20, 22, 26, 33, 34, 35, 36-р хороод</p>														
<p>Багц-4</p>	<p><b>Өдрийн үйлчилгээ:</b>  Төвийн бүс: 5, 6, 19, 21, 23, 27, 32, 37, 38, 39-р хороод,  Баянхошуу бүс: 7, 8, 9, 10, 11, 24, 25, 28, 40, 41, 42-р хороод</p>														
<p>Багц-5</p>	<p><b>Амьдралын итгэл үнэмшил олгох, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах үйлчилгээ</b></p>														
<p>Багц-6</p>	<p><b>Зөвлөгөө өгөх үйлчилгээ</b></p>														

<p><b>ТШЗ 2.1</b></p>	<p>Санхүүжилтийн эх үүсвэр: <b>Орон нутгийн төсвийн хөрөнгө</b>  Нийт төсөвт өртөг: <b>99,100,000 төгрөг</b>  <b>Тендер шалгаруулалтын төсөвт өртөг нь багц тус бүрээр. Үүнд:</b></p> <table border="1" data-bbox="432 271 1453 1402"> <tr> <td data-bbox="432 271 560 427">Багцын дугаар</td> <td data-bbox="560 271 1273 427">Багцын нэр төрөл, хамаарагдах газарзүйн байршил. /тухайн багцад орсон хороодын аль нэг байршилд үйл ажиллагаа явуулдаг ажлын байртай байх/</td> <td data-bbox="1273 271 1453 427">Нийт санхүүжилт</td> </tr> <tr> <td data-bbox="432 427 560 618">Багц-1</td> <td data-bbox="560 427 1273 618"><b>Сэргээн засах үйлчилгээ:</b> Өнөр бүс: 12, 13, 14, 15, 16, 17, 18, 29, 30, 31, 43-р хороод, Толгойт бүс: 1, 2, 3, 4, 20, 22, 26, 33, 34, 35, 36-р хороод</td> <td data-bbox="1273 427 1453 618">34,500,000</td> </tr> <tr> <td data-bbox="432 618 560 808">Багц-2</td> <td data-bbox="560 618 1273 808"><b>Сэргээн засах үйлчилгээ:</b> Төвийн бүс: 5, 6, 19, 21, 23, 27, 32, 37, 38, 39-р хороод, Баянхошуу бүс: 7, 8, 9, 10, 11, 24, 25, 28, 40, 41, 42-р хороод</td> <td data-bbox="1273 618 1453 808">34,500,000</td> </tr> <tr> <td data-bbox="432 808 560 999">Багц-3</td> <td data-bbox="560 808 1273 999"><b>Өдрийн үйлчилгээ:</b> Өнөр бүс: 12, 13, 14, 15, 16, 17, 18, 29, 30, 31, 43-р хороод, Толгойт бүс: 1, 2, 3, 4, 20, 22, 26, 33, 34, 35, 36-р хороод</td> <td data-bbox="1273 808 1453 999">6,300,000</td> </tr> <tr> <td data-bbox="432 999 560 1189">Багц-4</td> <td data-bbox="560 999 1273 1189"><b>Өдрийн үйлчилгээ:</b> Төвийн бүс: 5, 6, 19, 21, 23, 27, 32, 37, 38, 39-р хороод, Баянхошуу бүс: 7, 8, 9, 10, 11, 24, 25, 28, 40, 41, 42-р хороод</td> <td data-bbox="1273 999 1453 1189">6,300,000</td> </tr> <tr> <td data-bbox="432 1189 560 1357">Багц-5</td> <td data-bbox="560 1189 1273 1357"><b>Амьдралын итгэл үнэмшил олгох, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах үйлчилгээ</b></td> <td data-bbox="1273 1189 1453 1357">12,500,000</td> </tr> <tr> <td data-bbox="432 1357 560 1402">Багц-6</td> <td data-bbox="560 1357 1273 1402"><b>Зөвлөгөө өгөх үйлчилгээ</b></td> <td data-bbox="1273 1357 1453 1402">5,000,000</td> </tr> </table>	Багцын дугаар	Багцын нэр төрөл, хамаарагдах газарзүйн байршил. /тухайн багцад орсон хороодын аль нэг байршилд үйл ажиллагаа явуулдаг ажлын байртай байх/	Нийт санхүүжилт	Багц-1	<b>Сэргээн засах үйлчилгээ:</b> Өнөр бүс: 12, 13, 14, 15, 16, 17, 18, 29, 30, 31, 43-р хороод, Толгойт бүс: 1, 2, 3, 4, 20, 22, 26, 33, 34, 35, 36-р хороод	34,500,000	Багц-2	<b>Сэргээн засах үйлчилгээ:</b> Төвийн бүс: 5, 6, 19, 21, 23, 27, 32, 37, 38, 39-р хороод, Баянхошуу бүс: 7, 8, 9, 10, 11, 24, 25, 28, 40, 41, 42-р хороод	34,500,000	Багц-3	<b>Өдрийн үйлчилгээ:</b> Өнөр бүс: 12, 13, 14, 15, 16, 17, 18, 29, 30, 31, 43-р хороод, Толгойт бүс: 1, 2, 3, 4, 20, 22, 26, 33, 34, 35, 36-р хороод	6,300,000	Багц-4	<b>Өдрийн үйлчилгээ:</b> Төвийн бүс: 5, 6, 19, 21, 23, 27, 32, 37, 38, 39-р хороод, Баянхошуу бүс: 7, 8, 9, 10, 11, 24, 25, 28, 40, 41, 42-р хороод	6,300,000	Багц-5	<b>Амьдралын итгэл үнэмшил олгох, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах үйлчилгээ</b>	12,500,000	Багц-6	<b>Зөвлөгөө өгөх үйлчилгээ</b>	5,000,000
Багцын дугаар	Багцын нэр төрөл, хамаарагдах газарзүйн байршил. /тухайн багцад орсон хороодын аль нэг байршилд үйл ажиллагаа явуулдаг ажлын байртай байх/	Нийт санхүүжилт																				
Багц-1	<b>Сэргээн засах үйлчилгээ:</b> Өнөр бүс: 12, 13, 14, 15, 16, 17, 18, 29, 30, 31, 43-р хороод, Толгойт бүс: 1, 2, 3, 4, 20, 22, 26, 33, 34, 35, 36-р хороод	34,500,000																				
Багц-2	<b>Сэргээн засах үйлчилгээ:</b> Төвийн бүс: 5, 6, 19, 21, 23, 27, 32, 37, 38, 39-р хороод, Баянхошуу бүс: 7, 8, 9, 10, 11, 24, 25, 28, 40, 41, 42-р хороод	34,500,000																				
Багц-3	<b>Өдрийн үйлчилгээ:</b> Өнөр бүс: 12, 13, 14, 15, 16, 17, 18, 29, 30, 31, 43-р хороод, Толгойт бүс: 1, 2, 3, 4, 20, 22, 26, 33, 34, 35, 36-р хороод	6,300,000																				
Багц-4	<b>Өдрийн үйлчилгээ:</b> Төвийн бүс: 5, 6, 19, 21, 23, 27, 32, 37, 38, 39-р хороод, Баянхошуу бүс: 7, 8, 9, 10, 11, 24, 25, 28, 40, 41, 42-р хороод	6,300,000																				
Багц-5	<b>Амьдралын итгэл үнэмшил олгох, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах үйлчилгээ</b>	12,500,000																				
Багц-6	<b>Зөвлөгөө өгөх үйлчилгээ</b>	5,000,000																				
<b>Б. АГУУЛГА</b>																						
<p><b>ТШЗ 8.1</b></p>	<p>Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг:  Хариуцсан ажилтан: <b>Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн Нийгмийн халамжийн тасгийн дарга Б.Байгалмаа</b>  Хаяг: <b>Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 6 дугаар хороо, Ханын материалын эцэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, 202 тоот</b>  Утасны дугаар: <b>70174405, 92044404</b>  Цахим шуудангийн хаяг: <b>Baigalbold07@gmail.com</b></p>																					
<p><b>ТШЗ 10.1</b></p>	<p>Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: <b>“Үгүй”</b></p>																					

<b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>							
<b>ТШЗ 11.2</b>	Тендер шалгаруулалтын хэл: <b>“Монгол хэл”</b>						
<b>ТШЗ 14.1</b>	Хувилбарт санал ирүүлэхийг: <b>“Зөвшөөрөхгүй”</b>						
<b>ТШЗ 17.1</b>	Санхүүгийн чадавхын шаардлага: <b>Борлуулалтын орлогын хэмжээ: 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилийн нийт борлуулалтын орлогын хэмжээ нь тухайн багцын төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.</b>						
<b>ТШЗ 17.2</b>	Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг: <b>“Шаардана”</b>  <ul style="list-style-type: none"> <li>- <b>Үнэлгээнд харгалзах санхүүгийн тайлангийн хугацаа: Сүүлийн 3 жилийн аль нэг жилд гаргасан санхүүгийн тайлан</b></li> </ul> <p><b>2021, 2022, 2023 онуудын санхүүгийн тайланг цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн <a href="http://www.e-balance.mof.gov.mn">www.e-balance.mof.gov.mn</a> мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас сүүлийн 3 жилийн борлуулалтын орлого болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>Харилцагч банкны мэдэгдэл</b></li> </ul> <p><b>Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойшхи өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа /"Бүрэн скор ЗМС" ХХК (<a href="http://burenscore.mn">burenscore.mn</a>) эсвэл "Титан Си Ар Эй ЗМС" ХХК (<a href="http://sainscore.mn">sainscore.mn</a>) зээлийн мэдээллийн сангийн лавлагаа ирүүлнэ/</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>Сүүлийн 3 жилийн аль нэг жилийн хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл.</b></li> </ul>						
<b>ТШЗ 18.1</b>	Техникийн чадавх болон туршлагын шаардлага: <b>“Шаардана” МАЯГТЫН ДАГУУ</b> <b>Ажил гүйцэтгэх хүний нөөц: “Шаардана” /7 дугаар маягтын дагуу/</b>  <p><i>Гэрээг хэрэгжүүлэхэд санал болгож буй удирдах болон голлох боловсон хүчнүүдийн иргэний үнэмлэх, мэргэжлийг батлах диплом болон гэрчилгээний хуулбар, байгууллага нь ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэл төлдөг бол нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа, гэрээгээр ажиллаж байгаа бол хөдөлмөрийн гэрээ, чадвар туршлагын талаарх мэдээллийг нотлох баримт бичгийн хамтаар ирүүлэх. /Дипломын хуулбарыг нотариатаар баталгаажуулах бөгөөд нотариатын хугацаа нь хуульд заасан хугацааны шаардлагыг хангасан байх/.</i></p> <p><b>Багц 1, 2 - Сэргээн засах үйлчилгээ:</b></p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <tr> <td style="width: 10%; text-align: center;">Д/д</td> <td style="width: 40%; text-align: center;">Албан тушаал</td> <td style="width: 15%; text-align: center;">Хүний тоо</td> <td style="width: 35%; text-align: center;">Мэргэжлээрээ ажиллсан</td> </tr> </table>			Д/д	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажиллсан
Д/д	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажиллсан				

			туршлага
1.	Их эмч /уламжлалт/	1	1 болон түүнээс дээш жил
2.	Сувилагч	1	1 болон түүнээс дээш жил
3.	Нийгмийн ажилтан	1	1 болон түүнээс дээш жил
4.	Үйлчилгээний ажилтан	1	1 болон түүнээс дээш жил

**Багц 3, 4 - Өдрийн үйлчилгээ:**

Д/д	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажиллсан туршлага
1.	Удирдах ажилтан	1	1 болон түүнээс дээш жил
2.	Нийгмийн ажилтан	1	1 болон түүнээс дээш жил
3.	Үйлчилгээний ажилтан	1	1 болон түүнээс дээш жил

**Багц 5 - Амьдралын итгэл үнэмшил олгох, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах үйлчилгээ:**

Д/д	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажиллсан туршлага
1.	Мэргэжлийн сургагч багш	2	2 болон түүнээс дээш жил
2.	Нийгмийн ажилтан	1	1 болон түүнээс дээш жил
3.	Туслах ажилтан	1	1 болон түүнээс дээш жил

**Багц 6 - Зөвлөгөө өгөх үйлчилгээ**

Д/д	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажиллсан туршлага
1.	Мэргэжлийн сэтгэл зүйч, судлаач	2	2 болон түүнээс дээш жил
2.	Нийгмийн ажилтан	1	1 болон түүнээс дээш жил
3.	Туслах ажилтан	1	1 болон түүнээс дээш жил

**Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: “Багц 1, 2, 3, 4-ийн хувьд Шаардана” /9 дүгээр маягтын дагуу/**

**Багц 1, 2 - Сэргээн засах үйлчилгээ:**

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо хэмжээ
1	Хаш чулуун дулаан зохицуулах соронзон эмчилгээний ор	1-2
2	Нуруу ууцны иж бүрэн массажны ор	1-2
3	Толгойн цэгэн массажны аппарат	1-2
4	Хуянгийн массажны аппарат	1-2
5	Хөлийн улны цэгэн массажны тоног төхөөрөмж	1-2
6	Улаан гэрлэн шарлаганы аппарат тоног төхөөрөмж.	1
7	Бумба тавих хэрэгсэл	1-2

8	Төөнүүрийн хэрэгсэл	1-2
9	Дасгал хөдөлгөөн хийх хэрэгсэл	5
10	Гал унтраах хэрэгслээр хангагдсан байх	1

**Багц 3, 4 – Өдрийн үйлчилгээ:**

№	Тоног төхөөрөмжийн нэр
1.	Эмнэлгийн анхны тусламж, үйлчилгээ үзүүлэх хэрэгсэл
2.	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл /зурагт, хөгжим, ном, өдөр тутмын сонин сэтгүүл, гарын авлага гэх мэт/
3.	Хөгжөөнт болон оюуны тоглоом наадгай /шатар, даам, шагай, үндэсний тоглоом наадгай гэх мэт/
4.	Гал тогооны тоног төхөөрөмж /өдрийн цай бэлтгэхэд шаардлагатай хэрэгсэл/
5.	Буйдан, сэтгүүлийн ширээ
6.	Ширээ, сандалны иж бүрдэл
7.	Гал унтраах багаж хэрэгсэл

*Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийн жагсаалтыг гаргаж, фото зургийг хавсарган, тайлбарын хамтаар ирүүлнэ. /Тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийн фото зураг нь үйл ажиллагаа явуулах ажлын байранд байршсан байна/*

**Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: “Шаардана”**

*Ижил төстэй үйлчилгээ гүйцэтгэсэн туршлага: Сүүлийн 3 жилийн аль нэг жилд /2021, 2022, 2023 онд/ ижил төстэй үйлчилгээ гүйцэтгэсэн туршлагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг жагсаалтаар ирүүлэх. /2, 3 дугаар маягтын дагуу/*

**Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардана”**

*Ижил төстэй үйлчилгээ хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл /4 дүгээр маягтын дагуу/;*

**Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: “Шаардана”**

*Сүүлийн 3 жилийн аль нэгд ирүүлсэн ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээ, ажил хүлээлцсэн актын хуулбарын хамт ирүүлнэ. Гэрээний үүргийн биелэлтийг захиалагчийн техник хяналт хийсэн тодорхойлолтоос үндэслэн гэрээг хэрэгжүүлэх чадварын үнэлгээнд харгалзан үзнэ.*

Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: **“Шаардана”**

1. **Үнийн санал маягтын дагуу;**
2. **Байгууллагын танилцуулга;**
3. **Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэл;**
4. **Хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар.**
5. **Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын**

	<p><i>магадлан итгэмжлэлийн гэрчилгээ /2024 онд шинээр авсан болон сунгуулсан байгууллагад хамааралгүй/;</i></p> <p><b>6. Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн хуулбар /Сэргээн засах үйлчилгээ/; Тусгай зөвшөөрлийн хугацаа нь тендер хүчинтэй байх хугацаанд хүчин төгөлдөр байна. Хэрэв хугацаа дууссан бол эрх бүхий байгууллагын хугацааг сунгасан тухай шийдвэрийг ирүүлэх.</b></p> <p><b>7. Харилцагч банк, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас болон холбогдох бусад байгууллагаас лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай албан мэдэгдэл ирүүлнэ. Тодорхойлолт, мэдэгдлүүдийн он, сар, өдөр нь тендер зарлагдсан өдрөөс хойш байна.</b></p> <p><b>8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын өр төлбөргүй тухай тодорхойлолт</b></p> <p><b>9. Татварын байгууллагаас тодорхойлолт ирүүлэх. /Тендер зарласан өдрөөс хойших огноогоор ирүүлнэ, тодорхойлолтоор татварын ямар нэг өр буюу дутуу үлдэгдэлгүй байх/;</b></p> <p><b>10. Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт ирүүлэх. /Тендер зарласан өдрөөс хойших огноогоор ирүүлнэ, тодорхойлолтоор ямар нэг өр буюу дутуу үлдэгдэлгүй байх/;</b></p>
<p><b>ТШЗ 18.2</b></p>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг: <b>“Шаардана”</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>Сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд үзүүлсэн үйлчилгээний жагсаалт, тэдгээрээс ижил төстэй бараа, үйлчилгээний өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт</b></li> <li>- <b>Үйлчилгээ үзүүлэх хуваарийг V бүлгийн 6 дугаар маягтын дагуу ирүүлэх;</b></li> <li>- <b>Шаардсан хүний нөөцийн мэдээллийг V бүлгийн 7 дугаар маягтын дагуу ирүүлэх;</b></li> <li>- <b>Оролцогчийн туршлагыг харуулах заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний талаар V бүлгийн 2, 3 дугаар маягтын дагуу бэлтгэсэн мэдээлэл;</b></li> <li>- <b>Үйлчилгээ үзүүлэхэд ашиглахаар заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, үйлчилгээ явуулах ажлын байрны мэдээллийн талаар V бүлгийн 9 дүгээр маягтын дагуу (өөрийн өмчлөл, эзэмшлийн, түрээслэх гэх мэт);</b></li> <li>- <b>Техникийн чадавх болон туршлагын талаар заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлоход шаардлагатай бусад баримт.</b></li> </ul>
<p><b>ТШЗ 18.3</b></p>	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: <b>“Шаардана”</b></p> <ol style="list-style-type: none"> <li><b>1. Хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар.</b></li> <li><b>2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас олгосон үйлчилгээ явуулах магадлан итгэмжлэлийн гэрчилгээ /2024</b></li> </ol>

	<p><i>онд шинээр авсан болон сунгуулсан байгууллагад хамааралгүй/;</i></p> <p><b>3. Сэргээн засах үйлчилгээ үзүүлэх байгууллага нь эрх бүхий байгууллагаас эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл. Тусгай зөвшөөрлийн хугацаа нь тендер хүчинтэй байх хугацаанд хүчин төгөлдөр байна. Хэрэв хугацаа дууссан бол эрх бүхий байгууллагын хугацааг сунгасан тухай шийдвэрийг ирүүлэх.</b></p>
<b>ТШЗ 20.2</b>	Оролцогчийн санал болгосон тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>“Тохируулахгүй тогтмол байна”</b>
<b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ</b>	
<b>ТШЗ 24.4</b>	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ol style="list-style-type: none"> <li><b>1. Үнийн санал маягтын дагуу;</b></li> <li><b>2. Байгууллагын танилцуулга;</b></li> <li><b>3. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэл;</b></li> <li><b>4. Татварын байгууллагын тодорхойлолт;</b></li> <li><b>5. Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт;</b></li> <li><b>6. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;</b></li> <li><b>7. Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан;</b></li> <li><b>8. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын магадлан итгэмжлэлийн гэрчилгээ /2024 онд шинээр авсан болон сунгуулсан байгууллагад хамааралгүй/;</b></li> <li><b>9. Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн хуулбар /сэргээн засах үйлчилгээ/;</b></li> <li><b>10. Харилцагч банк, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас болон холбогдох бусад байгууллагаас лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай албан мэдэгдэл /Тодорхойлолт, мэдэгдлүүдийн он, сар, өдөр нь тендер зарлагдсан өдрөөс хойш байна/;</b></li> <li><b>11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын өр төлбөргүй тухай тодорхойлолт;</b></li> <li><b>12. Хуулийн 22.5-д заасан үндэслэлээр ил болгохгүй баримт бичиг, мэдээлэл байгаа бол түүний хууль зүйн үндэслэлийг тайлбарласан мэдэгдэл.</b></li> </ol>
<b>ТШЗ 25.1</b>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: <b>2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 00 минут</b></p>



### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

#### САНАМЖ

Захиалагч болон үнэлгээний хороо нь ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд захиалагчийн зураг төсөл (техникийн болон ажлын зураг, өртгийн төсөв), ажлын хуваарь, тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулан, уг барилга байгууламжийг ашиглалтад бэлэн болгохтой холбоотой ажил, бараа, үйлчилгээнд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа, үйлчилгээг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

### **III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТ, АЖЛЫН ДААЛГАВАР**

Нийгмийн халамжийн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ нь нийгмийн халамжийн зорилтот бүлгийн иргэдийн эрүүл мэндийн болон нийгэм, сэтгэлзүйн асуудлыг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх зорилготой.

Сонгон шалгаруулалтад оролцогч нь баримт бичгийг бэлтгэн ирүүлэх ба бүх материал тод байх бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно.

ТӨХ-д заасан материалуудаас аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд тухайн үнийн саналаас татгалзах үндэслэл болно.

Иймд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулахад тавигдах нөхцөл, шаардлагуудыг энэхүү ажлын даалгаварт тусгасан болно. Үүнд:

#### ***Нэг. Ерөнхий шаардлага:***

- 1. Магадлан итгэмжлэгдсэн байгууллага байна.*
- 2. Мэргэжлийн боловсон хүчин, ажилтнуудтай байна. /Боловсон хүчний танилцуулга, хийгдсэн ажлын туршлага*
- 3. Сургалт зохион байгуулах үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэж байгаа Төрийн бус байгууллага, Аж ахуйн нэгж нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/374 дүгээр тушаалаар баталсан “Амьдралын итгэл, үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах үйлчилгээний чанарт тавигдах шалгуурыг хангасан байна.*
- 4. Үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэн жилд 1 удаа тухайн үйлчилгээнд хамрагдах ба үйлчилгээний хамрагдах хугацаа аргачлалд заасны дагуу байна.*
- 5. Өдрийн үйлчилгээнд хамрагдах иргэд Ахмад настны тухай хуулийн 7.1.4-т заасан Өдрийн үйлчилгээнд давхцаж хамрагдахгүй.*
- 6. Зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагдах иргэд Ахмад настны тухай хуулийн 7.1.2-т заасан Зөвлөгөө өгөх үйлчилгээнд давхцаж хамрагдахгүй.*
- 7. Сэргээн засах үйлчилгээнд хамрагдсан иргэд өдрийн үйлчилгээнд хамрагдахгүй.*
- 8. Сэргээн засах үйлчилгээ үзүүлэх байгууллага нь эрүүл мэндийн тусгай зөвшөөрөлтэй байгууллага байна.*
- 9. Үйлчилгээ үзүүлэх багаж, тоног төхөөрөмж, эд хогшилоор бүрэн хангагдсан байна. /ТӨХ-т заагдсан багаж, тоног төхөөрөмж, эд хогшил гэх мэт, гэрэл зураг хавсаргах/*
- 10. Үйлчилгээ үзүүлэх өөрийн өмчийн болон түрээсийн байртай эсэхийг батлах бичиг баримтын хуулбарыг ирүүлэх /ажлын байрны гэрэл зураг хавсаргах/*
- 11. Байгууллага нь нийгмийн халамжийн зорилтот бүлгийн иргэдэд үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай байна.*
- 12. Үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэдэд ХХҮЕГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/12 тоот “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал”-д заагдсан үйлчилгээг чанартай, үнэн, зөв хүргэж, иргэдээс гарсан санал гомдлын асуудлыг шийдвэрлэх боломжтой байх.*
- 13. Үйлчилгээ үзүүлэх боловсон хүчин нь ТӨХ-т заагдсан шаардлагыг хангаж байх ажлын туршлага, мэргэжлийн ур чадвартай байна.*

14. Үйлчилгээг хэт ачаалал үүсгэхгүйгээр батлагдсан хуваарийн дагуу хугацаанд нь чанартай сайн гүйцэтгэж, сар бүрээр тайланг гаргуулна.
15. Үйлчилгээг үзүүлэхдээ тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, бэлэн байдлыг хангаж ажиллах бүрэн боломжтой байх.
16. Халамжийн зорилтот бүлгийн иргэдэд үйлчилгээг хүргэж байх хугацаанд бусад иргэдийн үйлчилгээтэй давхардуулахгүй байх.
17. Тендер ирүүлсэн байгууллагуудын үйл ажиллагаа явуулах ажлын байранд үнэлгээний хорооны гишүүд очиж танилцан, үйлчилгээнд тавигдах шаардлага хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гарган, үнэлгээ хийнэ.
18. Үйлчилгээ үзүүлэх байр нь эрүүл ахуйн шаардлага хангасан, эмнэлгийн зориулалтын байх ба үзлэг хийх эмч нь үзлэгийн өрөө эсвэл тасалгаатай байж, эмчийн танилцуулгыг байршуулсан байна.
19. Үйлчилгээнд хамруулахын өмнө иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгнө.

**Хоёр. Боловсон хүчний шаардлага: Үйлчилгээ гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцөд тавих шаардлага.**

Д/д	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан туршлага
Багц 1, 2 – Сэргээн засах үйлчилгээ			
1.	Их эмч /уламжлалт/	1	1 болон түүнээс дээш жил
2.	Сувилагч	1	1 болон түүнээс дээш жил
3.	Нийгмийн ажилтан	1	1 болон түүнээс дээш жил
4.	Үйлчилгээний ажилтан	1	1 болон түүнээс дээш жил
Багц 3, 4 – Өдрийн үйлчилгээ			
1.	Удирдах ажилтан	1	1 болон түүнээс дээш жил
2.	Нийгмийн ажилтан	1	1 болон түүнээс дээш жил
3.	Үйлчилгээний ажилтан	1	1 болон түүнээс дээш жил
Багц 5 – Амьдралын итгэл үнэмшил олгох, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах үйлчилгээ			
1.	Мэргэжлийн сургагч багш	2	2 болон түүнээс дээш жил
2.	Нийгмийн ажилтан	1	1 болон түүнээс дээш жил
3.	Үйлчилгээний ажилтан	1	1 болон түүнээс дээш жил
Багц 6 – Зөвлөгөө өгөх үйлчилгээ			
1	Мэргэжлийн сэтгэл зүйч, судлаач	2	2 болон түүнээс дээш жил
2	Нийгмийн ажилтан	1	1 болон түүнээс дээш жил
3	Туслах ажилтан	1	1 болон түүнээс дээш жил

- **Амьдралын итгэл үнэмшил олгох, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах үйлчилгээ:**
  1. Сургалт зохион байгуулах үйлчилгээний хөтөлбөрт үйл ажиллагааны үндсэн зорилгыг биелүүлэх, зохион байгуулах чадвартай удирдах албан тушаалтан болон сургагч багш, ажилтантай байна.
  2. Сургагч багш мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх.
  3. Бакалаврын зэрэгтэй, тухайн сургалт зохион байгуулах чиглэлийн диплом, үйлчилгээ үзүүлэх эрхийн гэрчилгээтэй мэргэжлийн Нийгмийн ажилтан, сэтгэл

зүйчтэй байх

4. Зорилтот бүлгийн иргэдийг өөртөө итгэх итгэл, амьдралын зорилго, утга учир, үнэ цэнэ, итгэл үнэмшил бий болгох, алсын хараа мөрөөдөлтэй амьдарч, хариуцлагатай болох, ирээдүйгээ зөв төлөвлөж, зохион байгуулж сурах, аж ахуй, бизнес эрхлэх үндсэн мэдлэг эзэмшүүлэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэгдсэн сургалт зохион байгуулах.
5. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хувь хүний хөгжил авьяас, чадварыг нь хөгжүүлж, дэмжихэд чиглэгдсэн сургалт зохион байгуулах.
6. Зорилтот бүлгийн иргэдэд хөдөлмөрийн дадал олгох сургалт зохион байгуулах. /гар урлал, сүлжмэл эдлэл, модон эдлэл, бэлэг дурсгал, оёдол, компьютерийн хэрэглээний болон цахим орчинд ажиллах анхан шатны мэдлэг, чадвар гэх мэт/
7. Зорилтот бүлгийн иргэдийг санхүүгийн болон бизнес эрхлэх суурь мэдлэг олгох.
8. Бие даан амьдрахад нь туслах зорилгоор чадвар олгох сургалт зохион байгуулах.

• **Зөвлөгөө өгөх үйлчилгээ:**

1. 2-оос дээш жил мэргэжлээрээ ажилласан мэргэжлийн Сэтгэл зүйч байх бөгөөд зөвлөгөө өгөх сэтгэл зүйч нь клиник сэтгэл судлал сэтгэл засал, сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх чиглэлээр мэргэшсэн байх
2. Тулгарч буй сэтгэлзүйн асуудал бэрхшээлтэй нөхцөл байдлыг оношлон тогтоох, шийдвэрлэхэд нь мэргэжлийн тусламж дэмжлэг үзүүлэх.
3. Амьдралын асуудлаа өөрсдөө шийдвэрлэхэд нь туслах.
4. Нийгмээс тусгаарлагдсан болон нийгэм, сэтгэлзүйн туслалцаа шаардлагатай зорилтот бүлгийн иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх.

**Гурав. Үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах багаж, тоног төхөрөмж, эд хогшлын жагсаалт**

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо хэмжээ
Багц 1, 2 - Сэргээн засах үйлчилгээ:		
1	Хаш чулуун дулаан зохицуулах соронзон эмчилгээний ор	1-2
2	Нуруу ууцны иж бүрэн массажны ор	1-2
3	Толгойн цэгэн массажны аппарат	1-2
4	Хуянгийн массажны аппарат	1-2
5	Хөлийн улны цэгэн массажны тоног төхөөрөмж	1-2
6	Улаан гэрлэн шарлаганы аппарат тоног төхөөрөмж.	1
7	Бумба тавих хэрэгсэл	1-2
8	Төөнүүрийн хэрэгсэл	1-2
9	Дасгал хөдөлгөөн хийх хэрэгсэл	5
10	Гал унтраах хэрэгслээр хангагдсан байх	1
Багц 3, 4 – Өдрийн үйлчилгээ		
1	Эмнэлгийн анхны тусламж, үйлчилгээ үзүүлэх хэрэгсэл	
2	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл /зурагт, хөгжим, ном, өдөр тутмын сонин сэтгүүл, гарын авлага гэх мэт/	
3	Хөгжөөнт болон оюуны тоглоом наадгай /шатар, даам, шагай, үндэсний тоглоом наадгай гэх мэт/	
4	Гал тогооны тоног төхөөрөмж /өдрийн цай бэлтгэхэд шаардлагатай хэрэгсэл/	

5	Буйдан, сэтгүүлийн ширээ
6	Ширээ, сандалны иж бүрдэл
7	Гал унтраах багаж хэрэгсэл

**Дөрөв. Үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажлын байранд тавигдах шаардлага**

**Багц 1, 2 - Сэргээн засах үйлчилгээ:**

1. Сэргээн засах үйлчилгээг явуулах шаардлага хангасан байртай байх. (өдөрт 10-15 иргэнд үйлчлэх зай талбайтай байх)
2. Үйлчилгээ үзүүлэх байрны хаяг байршил нь тухайн хорооны зорилтот бүлгийн иргэдэд саад, бэрхшээлгүй, зам дагуу байх. (орон сууцны хороололд байршилтай бол тухайн байрны 1 давхарт, гэр хороололд байршилтай бол зам дагуу, бартаа саадгүй, автобусны буудалтай ойр байх)
3. Цахилгаан, дулаан, цэвэр бохир усны хангамж, интернет, харилцаа холбоотой байна.
4. Тоног төхөөрөмжийн танилцуулга болон мэдээллийн самбар байршуулсан байна.
5. Үйлчилгээ үзүүлэх өрөө, хувцас солих өрөө, амрах өрөө, ариун цэврийн өрөөтэй байна.
6. Гэгээлэг дулаан уур амьсгал бүрдүүлсэн өнгө будалттай өрөө тасалгаатай, үйлчлүүлэгчийн амарч суухад хүрэлцээтэй тохилог сандал, ширээ, бусад хэрэгсэл бүхий орчны тохижилт хийгдсэн байна.

**Багц 3, 4 – Өдрийн үйлчилгээ**

1. Цахилгаан, дулаан, цэвэр бохир усны хангамж, интернет, харилцаа холбоотой байна.
2. Гэгээлэг, дулаан уур амьсгал бүрдүүлсэн өнгө будалттай өрөө тасалгаатай, үйлчлүүлэгчийн амарч суухад хүрэлцээтэй тохилог сандал, ширээ, бусад хэрэгсэл бүхий орчны тохижилт хийгдсэн байна.
3. Хүний амь нас, аюулгүй байдлыг хангах, ахуйн осол, гэмтэл аюул учруулж болохуйц эд зүйлсийн тухай жагсаалт, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулсан байна.
4. Галын аюулгүй ажиллагааны самбартай, гал унтраах хэрэгслээр хангагдсан байна.
5. Өдрийн үйлчилгээг зохион байгуулах өрөө, амрах өрөө, бие засах өрөө, хоолны өрөөтэй байна.
6. Эмнэлгийн анхны тусламж, үйлчилгээ үзүүлэх хэрэгсэлтэй байна.
7. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байх /зурагт, хөгжим, ном, өдөр тутмын сонин сэтгүүл, гарын авлага гэх мэт/
8. Хөгжөөнт болон оюуны тоглоом наадгай, сургах, зохион байгуулах /шатар, даам, шагай, үндэсний тоглоом наадгай гэх мэт/

**Багц 5, 6 - Амьдралын итгэл үнэмшил олгох, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах үйлчилгээ, Зөвлөгөө өгөх үйлчилгээ**

1. Цахилгаан, дулаан, цэвэр бохир усны хангамж, интернет, харилцаа холбоотой байна.
2. Гэгээлэг, дулаан уур амьсгал бүрдүүлсэн өнгө будалттай өрөө тасалгаатай, үйлчлүүлэгч, үйлчлүүлэгчийн амарч суухад хүрэлцээтэй тохилог сандал, ширээ, бусад хэрэгсэл бүхий орчны тохижилт хийгдсэн байна.

Багц тус бүрт үйлчилгээ үзүүлэх иргэдийн тоо, мөнгөн дүн: / төгрөгөөр /

Багцын дугаар	Үйлчилгээний нэр төрөл	Нэг өдөрт үйлчлэх иргэний тоо	Нэг иргэний нэг өдрийн үйлчилгээний зардлын дээд хэмжээ	Нэг сард үйлчлэх иргэний тоо /хоног/	Нэг иргэнд нэг удаа үйлчлэх үйлчилгээний зардлын дээд хэмжээ	Нэг жилд үйлчлэх иргэний тоо	Нэг жилийн үйлчилгээний зардлын дээд хэмжээ
Багц-1	Сэргээн засах үйлчилгээ:	10 иргэн	43,500	20 иргэн /7 хоног/	304,500	115 иргэн	34,500,000
Багц-2	Сэргээн засах үйлчилгээ:	10 иргэн	43,500	20 иргэн /7 хоног/	304,500	115 иргэн	34,500,000
Багц-3	Өдрийн үйлчилгээ:	10 иргэн	15,000	20 иргэн /7 хоног/	105,000	60 иргэн	6,300,000
Багц-4	Өдрийн үйлчилгээ:	10 иргэн	15,000	20 иргэн /7 хоног/	105,000	60 иргэн	6,300,000

Багц	Үйлчилгээний нэр төрөл	1 иргэн хамрагдах хугацаа	1 иргэн 1-5 хоногт хамрагдах сургалтын цагийн дээд хэмжээ	Нэг ангид суралцагчийн дээд хэмжээ	Нийт суралцагчийн тоо	Нэг жилийн үйлчилгээний зардлын дээд хэмжээ
Багц 5	Сургалт зохион байгуулах үйлчилгээ	1-5 хоног	3-15 цаг	15-20 иргэн	230	12,500,000
Багц	Үйлчилгээний нэр төрөл	1 иргэн хамрагдах тоо	Нэг удаагийн зөвлөгөө өгөх хугацаа	Нэг өдөрт зөвлөгөө авах иргэний тоо	Нийт зөвлөгөө өгөх хүний тоо	Нэг жилийн үйлчилгээний зардлын дээд хэмжээ
Багц 6	Зөвлөгөө өгөх үйлчилгээ	1-3 удаа	20-40 минут	10 иргэн	62	5,000,000

**Нэмэлт тайлбар:** Тендерт оролцогч байгууллага нь үнийн санал ирүүлэхдээ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/12 тоот тушаалаар батлагдсан **“Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал”-д** заасан жишиг үнээс хэтрүүлэхгүй.

#### **IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

1. Үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: **“Ашиглахгүй”**

Хэрэв “ашиглах” бол урсгал засвар үйлчилгээний цэг бий болгох болон үндсэн/шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангахын тулд захиалагчид шаардагдах зардлыг тусад нь үнэлж ирүүлсэн бол түүнийг үнэлгээний зорилгоор тендерийн харьцуулах үнэ дээр нэмж үнэлнэ.

2. Байгаль орчинд нөлөөлөх байдал: **“Ашиглахгүй”**

Гэрээний гүйцэтгэлийн явцад байгаль орчинд нөлөөлөх байдалтай холбоотой дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ. **[Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]**

3. Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: **“Ашиглахгүй”**

Гэрээний гүйцэтгэлд хамаарах хуульд нийцсэн дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ. **[Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]**

Тухайлбал хуулийн 12.3-т заасныг үндэслэн тендерийн үнэлгээнд эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх тендерийн харьцуулах үнийг тодорхойлж болно

## V БҮЛЭГ.ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

### Маягт 1.Тендер илгээх маягт

[огноо]

#### [Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу үйлчилгээ үзүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
  - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
  - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
  - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
  - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [**“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих**]. [**Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих**].
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [**30 ба түүнээс дээш хоногийн тоо**] хоногийн хугацаанд хүчинтэй байна.<sup>1</sup>
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.

<sup>1</sup> Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендерийн баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.



8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

***[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,***

***эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,***

***албан тушаал, гарын үсэг,***

***байгууллагын тамга, тэмдэг]:***

***Хаяг:***

**Маягт 1 Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

**Маягт 3. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

Оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].*

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

**Маягт 4. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

**Маягт 5. Үйлчилгээг үзүүлэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга**

Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврыг гүйцэтгэх аргачлалын талаарх танилцуулга болон хэрэв ажлын даалгаврын талаар гаргах санал, ирүүлнэ.

**Маягт 6. Үйлчилгээ үзүүлэх хуваарь**

Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврын дагуу үзүүлэх үйлчилгээг гүйцэтгэх хуваарийг боловсруулж ирүүлнэ.

## Маягт 7. Хүний нөөцийн мэдээлэл

Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

## Маягт 8. Санал болгож буй ажилтны жишиг намтар (сv)

Санал болгож буй албан тушаал: \_\_\_\_\_

Овог, нэр: \_\_\_\_\_

Мэргэжил: \_\_\_\_\_

Төрсөн он, сар, өдөр: \_\_\_\_\_

Тухайн байгууллагад ажилласан жил: \_\_\_\_\_ Иргэншил: \_\_\_\_\_

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: \_\_\_\_\_

Хариуцах ажил: \_\_\_\_\_

Ур чадварын:

*[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн зөвлөх үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршлыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]*

Боловсрол:

*[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]*

Ажилласан туршлага:

*[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]*

Хэлний мэдлэг:

*[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшинг ярих, унших, бичих тус бүрт онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]*

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

**Маягт 9. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл**

<b>Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт</b>	<b>Хүчин чадал</b>	<b>Тоо ширхэг</b>	<b>[“Өөрийн эзэмшил” эсхүл “түрээс” аль нэгийг бичих]</b>

**Маягт 10. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

	<b>Нууцалсан баримт бичиг, мэдээлэл</b>	<b>Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл</b>
1.		
2.		
3.		
4.		
5.		

## VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж үйлчилгээ үзүүлэхэд энэхүү гэрээний загварыг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), гэрээ баталгаажуулах маягт, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас ажил, түүнтэй холбогдох бараа нийлүүлэх, үйлчилгээг үзүүлэх харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн ажлыг гүйцэтгүүлэх нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн ажлыг гүйцэтгэхэд хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;

1. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
2. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцох бол түүнийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
3. Гүйцэтгэх ажил, дагалдах бараа, үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
4. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
5. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг, өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
6. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.

# ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

## НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:
  - 1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
  - 1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
  - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
  - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
  - 1.1.7. “Үйлчилгээ” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
  - 1.1.8. “Ажлын байр” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
  - 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
  - 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
  - 1.1.11. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Тайлбар

- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
  - 1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.
  - 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
  - 1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад

нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

#### **ХОЁР. ЗАХИАЛАГЧ**

Захиалагчийн үүрэг	нийтлэг	2.1.	Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.
		2.2.	Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.
		2.3.	Захиалагч нь үйлчилгээ авахтай холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.

Захиалагчийн төлөөлөгч		2.4.	Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.
		2.5.	Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.
		2.6.	Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

Талбайд зөвшөөрөл	нэвтрэх	2.7.	Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.
		2.8.	Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.

#### **ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ**

Гүйцэтгэгчийн үүрэг	нийтлэг	3.1.	Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.
		3.2.	Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.
		3.3.	Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.
		3.4.	Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.
		3.5.	Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.
		3.6.	Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
		3.7.	Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.

- |                                       |   |
|---------------------------------------|---|
| Гүйцэтгэгчийн төлөөлөгч               | 3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.  |
|                                       | 3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.   |
|                                       | 3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.   |
| Техникийн болон ажлын талбайн өгөгдөл | 3.11. Захиалагч нь үйлчилгээтэй холбоотой нөхцөл байдлын талаарх өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.  |
| Аюулгүй байдал                        | 3.12. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ. |
|                                       | 3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.   |
|                                       | 3.14. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.  |
|                                       | 3.15. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.   |
|                                       | 3.16. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.   |
|                                       | 3.17. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.   |
|                                       | 3.18. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.   |

#### **ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН**

- |                |  |
|----------------|--|
| Ажил эхлэх     | 4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.   |
|                | 4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.   |
|                | 4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна. |
|                | 4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.  |
| Хугацаа сунгах | 4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:  |
|                | 4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;  |
|                | 4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;   |
|                | 4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ   |



- биелүүлээгүй;
- 4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.
- 4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.
- 4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.
- 4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
- Ажлын явцын тайлан 4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.
- 4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.

#### **ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

- Гэрээний үнэ 5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.
- 5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.
- Урьдчилгаа төлбөр 5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.
- 5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.
- Төлбөрийн нөхцөл 5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.
- 5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
- 5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
- 5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.
- 5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
- 5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах

эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана.

### **ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА**

- |                               |       |  |
|-------------------------------|-------|--|
| Урьдчилгаа төлбөрийн баталгаа | 6.1.  | ГЕН-ийн 5.4-д заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ.   |
| Гүйцэтгэлийн баталгаа         | 6.2.  | Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.                               |
|                               | 6.3.  | Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:<br>6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;<br>6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;<br>6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон. |
|                               | 6.4.  | Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.  |
|                               | 6.5.  | ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.  |
|                               | 6.6.  | Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.   |
| Чанарын баталгаа              | 6.7.  | Үйлчилгээний чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.   |
|                               | 6.8.  | Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно.  |
|                               | 6.9.  | ГЕН-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.   |
|                               | 6.10. | Баталгаат хугацаанд үйлчилгээнд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.   |
|                               | 6.11. | ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.   |
|                               | 6.12. | ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.  |
| Баталгаат хугацаа             | 6.13. | Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.   |
|                               | 6.14. | Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.  |

## ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ

- |                            |           |      |  |
|----------------------------|-----------|------|--|
| Бусдад<br>хохирлыг арилгах | учруулсан | 7.1. | Үйлчилгээ үзүүлэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.   |
|                            |           | 7.2. | Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.   |
| Захиалагчийн<br>эрсдэл     | хүлээх    | 7.3. | Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:<br>7.3.1. Үйлчилгээний үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;<br>7.3.2. гүйцэтгэсэн үйлчилгээг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;<br>7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас үйлчилгээ, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;<br>7.3.4. Захиалагчийн ажлын даалгаврын алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл. |
|                            |           | 7.4. | Үйлчилгээний доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.   |
| Даатгал                    |           | 7.5. | Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.  |
|                            |           | 7.6. | Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.   |
|                            |           | 7.7. | Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.   |
|                            |           | 7.8. | Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.   |
|                            |           | 7.9. | Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.   |
|                            |           |      | <b>НАЙМ. ДОГОЛДОЛ</b>  |
| Доголдлыг<br>арилгах       | илрүүлэх, | 8.1. | Гүйцэтгэгчээс ирүүлсэн үйлчилгээ, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна.   |
|                            |           | 8.2. | Захиалагчийн төлөөлөгч үйлчилгээний явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.  |
|                            |           | 8.3. | Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.   |

- 8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.
- 8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
- 8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.
- 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.
- 8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.
- 8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- 8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна.
- 8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.

#### **ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ**

- Захиалагч гэрээг цуцлах 9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
  - 9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үйлчилгээ үзүүлээгүй;
  - 9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй;
  - 9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;
  - 9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;
  - 9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
  - 9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;
  - 9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.
  - 9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.
- 9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.

- Гүйцэтгэгч гэрээг цуцлах 9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;
- 9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
- 9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.
- Гэрээг цуцлах журам 9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
- 9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.
- 9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.
- 9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.
- Гэрээг цуцалсны дараах төлбөр 9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.
- 9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:
- 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;
- 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;
- 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
- 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
- 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

## АРАВ. БУСАД ЗААЛТ

- Мэдэгдэл
- 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.
  - 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
  - 10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
  - 10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
    - 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
    - 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
  - 10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
  - 10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
  - 10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.
- Төлөөлөгч өөрчлөгдөх
- 10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.
  - 10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
  - 10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.
  - 10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.
- Үйлчилгээнд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл
- 10.12. Талууд үйлчилгээний чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.
  - 10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.
  - 10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.
  - 10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг

Гэнэтийн давагдашгүй шинжтэй онцгой байдал	буюу хүчний нөхцөл	<p>Гүйцэтгэгч хариуцна.</p> <p>10.16. Үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p>
		<p>10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p>
		<p>10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p>
		<p>10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-д заасан хүсэлтийг гаргаж болно.</p>
Оюуны зөрчих	өмчийн эрх	<p>10.20. Үйлчилгээг үзүүлэх явцад болон үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсэн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.</p>
Алданги		<p>10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.</p>
		<p>10.22. Гүйцэтгэгч нь үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.</p>
		<p>10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.</p>
		<p>10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.</p>
Маргаан шийдвэрлэх		<p>10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.</p>
		<p>10.26. Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.</p>

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 4.1.	Үйлчилгээ үзүүлж эхлэх хугацаа: <b>Гэрээ байгуулсан өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл</b>
ГЕН 4.2.	Үйлчилгээ үзүүлэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: <b>Гэрээ байгуулсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор</b>
ГЕН 4.9.	Үйлчилгээний явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: <b>Сар бүрийн 25-ны өдөр</b>
ГЕН 5.2.	Үнийн тохируулга: <b>“Хийхгүй”</b>
ГЕН 5.4.	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: <b>“Тийм”</b> <b>Хэрвээ урьдчилгаа төлбөр олгох бол:</b> Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: <b>Сар бүрийн тайланг хянаж дууссаны дараа гүйцэтгэлээр нь санхүүжилтийг олгоно.</b>
ГЕН 5.5.	Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: <b>Дараа сарын 25-ны өдөр</b>
ГЕН 5.6.	Төлбөр төлөх хугацаа: <b>Сар бүрийн тайланг хянаж дууссаны дараа гүйцэтгэлээр нь санхүүжилтийг олгоно.</b> Төлбөрийг хэсэгчилсэн төлөх бол төлбөр төлөх үе шатны хугацаа: <b>Сар бүрийн 25-ны өдөр</b>
ГЕН 6.1.	Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: <b>Гүйцэтгэлээр</b> Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа: <b>Шаардахгүй</b>
ГЕН 6.7.	<b>Чанарын баталгаа:</b> Чанарын баталгаа шаардах эсэх: <b>“Шаардахгүй”</b>
ГЕН 6.13.	Баталгаат хугацаа:
ГЕН 7.5.	Даатгал: <b>“Шаардахгүй”</b>
ГЕН 10.21.	Захиалагчийн төлөх алдангийн хувь: <b>Алданги тооцохгүй</b>
ГЕН 10.22.	Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: <b>Алданги тооцохгүй</b>



## ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах гэрээ.

Дугаар № **СХДХХҮХ/20240203002**

Улаанбаатар хот

Нэг талаас **Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс** (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас **[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]** (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Үйлчилгээ” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Үйлчилгээний үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч **[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
  - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
  - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
  - 3.6. Урьдчилгаа төлбөрийн баталгаа;
  - 3.7. Техникийн тодорхойлолт;
  - 3.8. Үйлчилгээ үзүүлэх хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
  - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр: Эрдэнэбилэг  
Нэр: Энхтуул

Албан тушаал: Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга

Ажлын утас: 70174405

Гар утас: 99054761

Цахим шуудан: info.songinhairhan.hudulmur-halamj.gov.mn

4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

***Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга Э.Энхтуул***

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

***Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн Нийгмийн халамжийн тасгийн дарга Б.Байгалмаа***

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024 оны 02 дугаар сарын 21-ний өдөр**  
Тендер шалгаруулалтын төрөл: **Үйлчилгээ**  
Тендер шалгаруулалтын нэр: **Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах**  
Тендер шалгаруулалтын дугаар: **СХДХХҮХ/20240203002**  
Нийт төсөвт өртөг: **99,100,000**  
Тендер шалгаруулалтын арга: **Харьцуулалт**

1. **Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **“Тийм”**

Багцын дугаар	<b>Багцын нэр төрөл, хамаарагдах газарзүйн байршил:</b> <i>/тухайн багцад орсон хороодын аль нэг байршилд үйл ажиллагаа явуулдаг ажлын байртай байх/</i>
Багц-1	<b>Сэргээн засах үйлчилгээ:</b> Өнөр бүс: 12, 13, 14, 15, 16, 17, 18, 29, 30, 31, 43-р хороод, Толгойт бүс: 1, 2, 3, 4, 20, 22, 26, 33, 34, 35, 36-р хороод
Багц-2	<b>Сэргээн засах үйлчилгээ:</b> Төвийн бүс: 5, 6, 19, 21, 23, 27, 32, 37, 38, 39-р хороод, Баянхошуу бүс: 7, 8, 9, 10, 11, 24, 25, 28, 40, 41, 42-р хороод
Багц-3	<b>Өдрийн үйлчилгээ:</b> Өнөр бүс: 12, 13, 14, 15, 16, 17, 18, 29, 30, 31, 43-р хороод, Толгойт бүс: 1, 2, 3, 4, 20, 22, 26, 33, 34, 35, 36-р хороод
Багц-4	<b>Өдрийн үйлчилгээ:</b> Төвийн бүс: 5, 6, 19, 21, 23, 27, 32, 37, 38, 39-р хороод, Баянхошуу бүс: 7, 8, 9, 10, 11, 24, 25, 28, 40, 41, 42-р хороод
Багц-5	<b>Амьдралын итгэл үнэмшил олгох, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах үйлчилгээ</b>
Багц-6	<b>Зөвлөгөө өгөх үйлчилгээ</b>

3. Үнийн санал дуудах ажиллагаанд шаардлагатай оролцогчийн тоо: **2 болон түүнээс дээш**
4. Үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлэх журам: **“Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”**
5. Үнийн санал дуудах ажиллагааг **2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 20 минутад** эхлүүлж, **2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 12 цаг 25 минут хүртлэх** хугацаанд зохион байгуулна.
6. Тендерийг **2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 10 цагаас** өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 10 минутад** нээнэ.
7. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх **“Зөвшөөрөхгүй”**
8. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **“Эрхгүй”**
9. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

**Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 6 дугаар хороо, Ханын материалын эцэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, 202 тоот**

**Цахим хаяг: info.songinhairhan.hudulmur-halamj.gov.mn Утас: 70174405, 92044404**